



## БАРАА МАТЕРИАЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2024 оны 12-р сарын 10 -ны өдөр №

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг Монгол Улсын Иргэний хуулийн 22 дугаар бүлгийг үндэслэн нэг талаас “ Завхан аймгийн УЦУОШТӨВ” түүнийг төлөөлж тус байгууллагын дарга Э.Мөнгөнцэцгэ /цаашид "Худалдан авагч гэх/, негеэ талаас “Нүүдэлчин Эко Ресурс” ХХК (Регистрийн дугаар 6991033) түүнийг төлөөлж Н.Наранбат/цаашид "Нийлүүлэгч" гэх /нар /цаашид худалдан авагч болон нийлүүлэгчийг тус бүрд нь “тал”, хамтад нь “талууд” гэх/ Монгол Улсын Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын тоот тушаал “эрх шилжүүлэх тухай” 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/837 дугаартай тушаалыг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав

### Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр нийлүүлэгч нь худалдан авагчийн захиалгын дагуу агаар орчны бохирдлыг бууруулах чиглэлээр орон нутагт утаагаа дахин шатаах давхар шаталтад эко зуухыг турших туршилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд /цаашид "бараа" гэх/-ыг нийлүүлэх, худалдан авагч нь барааг хүлээн авч, төлбөрийг төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Барааны нэр төрөл: Утаагаа дахин шатаах давхар шаталтад зуух
- 1.3. Барааны тоо хэмжээ: 14 ширхэг
- 1.4. Иж бүрдэл: Яндан 3м, дэгээ төмөр 1ш, ул ширэм, тосгуур, тавсан Зширхэг.
- 1.5. Худалдан авалтын захиалга, барааны чанар стандартыг тодорхойлсон бусад холбогдох баримт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно. /Хавсралт №1 Техникийн тодорхойлолт/

### Хоёр. БАРАА НИЙЛҮҮЛЭХ НӨХЦӨЛ

- 2.1. Нийлүүлэгч нь Худалдан авалтын захиалгад заасан тоо ширхэг , үзүүлэлт бүхий барааг харилцан тохиролцсон үнээр, хугацаандаа, худалдан авагчийн шаардлагын дагуу гэрээгээр тогтоосон газарт нийлүүлэх үүрэг хүлээнэ.
- 2.2. Нийлүүлэгч нь бараа нийлүүлэхдээ дор дурдсан үүргийг хүлээнэ:
- 2.3. Биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй холбогдох шаардлага хангасан барааг, хугацаанд нь нийлүүлэх,
- 2.4. Нийлүүлэгч нь холбогдох хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, эрх зүйн актуудыг чанд сахин мөрдөж ажиллах;
- 2.5. Худалдан авагч, түүний эрх бүхий төлөөлөгчийн тавьсан хууль ёсны шаардлага, зааварчилгааг биелүүлэх,
- 2.6. Бараа нийлүүлэх явцдаа байгаль орчинд хохирол учруулахгүй байх, сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээ авах,
- 2.7. Барааг нийлүүлэх явцад худалдан авагчийн болон бараа нийлүүлэх газарт ажиллаж буй худалдан авагчийн гэрээлэгч эсхүл гуравдагч этгээдийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй саад учруулахгүй,



- 2.8. Худалдан авагчийн эзэмшлийн газар талбай, бүсэд нэвтрэн орох бол нийлүүлэгч өөрөө болон түүний ажиллагсад төлөөлөгч, гэрээлэгч нь аюулгүй ажиллагааг бүрэн хангаж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй хэмжээнд ажлаа зохион байгуулах, ноогдсон ажлыг чанартай бүрэн гүйцэтгэх чадвартай мэргэшсэн этгээд байх нөхцөлийг хангах,
- 2.9. Худалдан авагчид бараа үйлчилгээтэй холбогдуулан худалдан авагчийн хүссэн, эсхүл шаардлагатай гэж үзсэн бүх мэдээлэл туслалцаагаар хангаж хамтран ажиллах үүрэгтэй,
- 2.10. Нийлүүлэгч нь дор дурдсан баталгааг худалдан авагчин өмнө гаргана.
- 2.11. Худалдан авалтын захиалга энэхүү гэрээний стандарт нөхцөл, тусгай нөхцөл тэдгээрийн хавсралт, захиалсан бараанд тавигдах шаардлага, үзүүлэлт, тодорхойлолтод заасан нөхцөлийг биелүүлэх,
- 2.12. Бараа нь аюулгүй бөгөөд зориулалтын дагуу ашиглагдах боломжтой ба үйлчилгээ мэргэжлийн түвшинд чанартай гүйцэтгэгдэх;
- 2.13. Барааны баглаа боодол нь зохих ёсоор, стандартын дагуу хийгдсэн,
- 2.14. Тухайн бараатай холбоотой гуравдагч этгээдийн шаардлага үүсээгүй, ирээдүйд үүсэхгүй, барааг худалдан авагч өмчлөлдөө хүлээн авахад ямар нэг саад болох зүйл байхгүй болох,
- 2.15. Нийлүүлэгч нь бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хуульд заасан тусгай зөвшөөрөл эрхийн гэрчилгээтэй уг зөвшөөрөл нь гэрээний хугацаанд хүчинтэй байх бөгөөд өөрийн үил ажиллагааны талаар худалдан авагчид гаргаж баримт бичиг, мэдээлэл нь үнэн зөв болох;

### **Гурав. НИЙЛҮҮЛЭХ БАРААНЫ ЧАНАР, ШИНЖ БАЙДАЛ**

- 3.1. Нийлүүлэгч нь Худалдан авалтын захиалгад заасан тоо хэмжээ, үнэ, нэр төрөл бүхий барааг заасан хугацаанд нийлүүлнэ.
- 3.2. Бараа нь худалдан авагчийн шаардлага, үзүүлэлтэд тохирсон, чанартай, эрхийн болон биет байдлын доголдолгүй, зориулалтын дагуу ашиглагдах боломжтой, иж бүрэн байх ба Худалдан авалтын захиалгад өөрөөр заагаагүй бол шинэ бараа байна.
- 3.3. Захиалгын шаардлага хангаагүй бараа нийлүүлсэн үйлчилгээ үзүүлсэн бол үүнтэй холбоотой хохирол, үр дагаврыг нийлүүлэгч бүрэн хариуцна.
- 3.4. Бараа хүргэх нөхцөл, захиалсан барааны шинж байдал, овор хэмжээ зэргээс хамааруулж барааг хүргэх үед нэг бүрчлэн шалгаж үзэх боломжгүй бол энэ талаар бараа хүлээлгэн өгөх баримт бичигт тэмдэглэнэ

### **Дөрөв. БАРААНЫ ҮНЭ**

- 4.1. Нийлүүлэх барааны нийт үнэ 19,800,000₮ /Арван есөн сая долоон зуун тавин мянган төгрөг/ байна. Үнийн дунд НӨАТ орсон болно.
- 4.2. Барааны үнэд Худалдан авалтын захиалгад өөрөөр заагаагүй бол барааг үйлдвэрлэх, нийлүүлэх, ачих, тээвэрлэх, бараа нийлүүлэх газарт хүргэх, суурилуулах-угсрал, турших-шалгах зардал зэрэг бүхий л зардал багтсан үнэ гэж үзнэ.
- 4.3. Нийлүүлэгч нь барааны үнийг нэмэх эрхгүй ба худалдан авагч Худалдан



- авалтын захиалгад заасан үнээс илүү ямар нэг төлбөрийг төлөх үүрэг хүлэхгүй
- 4.4. Худалдан авалтын захиалгын дагуу хүлээлцэх актаар хүлээн авсан барааны төлбөрийг Нийлүүлэгчээс ирүүлсэн нэхэмжлэх, Захиалгын хуудас, бараа хүлээлцэх актыг үндэслэн 3 хоногийн хугацаанд шилжүүлнэ

### **Тав.БАРААНЫ БАГЛАА БООДОЛ, БАРААГ ХҮРГЭХ**

- 5.1. Барааг хугацаанд нь, заасан газарт бэлэн байлгах нь нийлүүлэгчийн нэн тэргүүний зорилт байх ба давагдашгүй хүчин зүйлийн улмаас бараа нийлүүлэх хугацаанд өөрчлөлт орох, хойшлох зайлшгүй шаардлага гарсан бол нийлүүлэгч худалдан авагчид нэн даруй бичгээр мэдэгдэж, цаашид хэрхэн ажиллах тухай зааварчилгаа авна.
- 5.2. Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэх газар хүргэж эсхүл Барааг хүлээлгэн өгч, холбогдох үйлчилгээг бүрэн үзүүлж, дор дурдсан мэдээллийг агуулсан Бараа хүлээлцэх баримт бичгийг худалдан авагчид хүлээлгэн өгч, актанд гарын үсэг зуруулна.
- 5.3. Зарлагын падаан (Худалдан авалтын захиалгын дугаар, холбогдох гэрээний дугаарыг тусгасан байна),
- 5.4. Нийлүүлсэн бараа, үйлчилгээг тодорхой бичиж, тоо хэмжээ, хугацааг зааж өгөх.
- 5.5. Нийлүүлсэн бараа үйлчилгээг хүлээн авах газар;
- 5.6. Хэрэв барааг хүлээн авах үед бараа нь доголдолтой болох нь илэрхий бол худалдан авагч 5.3-д заасан баримтанд гарын үсэг зурж баталгаажуулах үүрэг хүлэхгүй

### **Зургаа. БАТАЛГААТ ХУГАЦАА**

- 6.1. Нийлүүлэгч нь нийлүүлсэн бараанд дөрвөн жилийн чанарын баталгаат хугацаа олгоно.

### **Долоо. ХАРИУЦЛАГА**

- 7.1. Талуудын аль нэг нь гэрээний үүргээ биелүүлээгүй бол үүнээс үүсэх хариуцлагыг буруутай тал хүлээнэ.
- 7.2. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь зохих есоор биелүүлээгүй бол хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн дүнгээс Худалдан авалтын захиалгад өөрөөр заагаагүй тохиолдолд 0 5% алданги төлөх хариуцлага хүлээнэ. Гүйцэтгээгүй үнийн дүнг тодорхойлох боломжгүй бол Худалдан авалтын захиалгын нийт үнийн дүнгээс тооцно.

### **Найм. НУУЦ ХАДГАЛАХ**

- 8.1. Нийлүүлэгч өөрөө болон түүний ажилтан, төлөөлөгч нь энэ гэрээ болон энэ гэрээний дагуу бараа нийлүүлэх явцад илэрхий болсон худалдан авагчийн бизнесийн нууц, нийтэд ил болгоогүй мэдээлэл, баримт бичгийн нууцлалыг чанд хадгалах ба худалдан авагчийн урьдчилж өгсөн бичгэн зөвшөөрөлгүйгээр дараах үйлдлийг хийхийг хориглоно.
- 8.2. Худалдан авагчийн нууцад хамааралтай мэдээллийг задруулах, нийтэд ил



- 8.3. болгох гуравдагч этгээдэд мэдэгдэх,  
8.4. Худалдан авагчийн нэр, байгууллагын барааны тэмдгийг ашиглах,  
8.4. Өөрт болон гуравдагч этгээдэд ашиг олох зорилгоор нууц мэдээллийг бусад  
байдлаар ашиглах,  
8.5. Нууц хадгалах тухай энэхүү заалт нь гэрээ дуусгавар болсны дараа  
тодорхойгүй хугацаагаар хүчин төгөлдөр үйлчилнэ

### **Ес. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ**

- 9.1. Энэ гэрээний хугацаанд байгалийн гамшиг, дайн, иргэний бослого. олон  
нийтийг хамарсан өвчин, хорио цээр, цаг агаарын байдал, төрийн эрх бүхий  
байгууллагын шийдвэр зэрэг талуудын хяналтаас гадуур бий болсон нөхцөл  
байдлын улмаас талууд хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй бол энэ  
талаар нөгөө талдаа бичгээр нэн даруй мэдэгдэнэ.
- 9.2. Давагдашгүй хүчин зүйлд автсан тал нь давагдашгүй хүчин зүйлийн үр  
дагавар, талуудын эд хөрөнгө, ажиллагсдын эрүүл мэндэд учирч болох  
хохирлыг багасгах талаар шуурхай арга хэмжээ авах үүрэгтэй Ийнхүү сайн  
дүрын үндсэн дээр өөрөөс шалтгаалах бүх арга хэмжээг авсан бол  
хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болно.
- 9.3. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас учирсан хохирол, нөхцөл байдлыг аль  
болов богино хугацаанд сэргээх ажлыг талууд тохиролцон авч хэрэгжүүлэх  
ба энэ үед тухайн нөхцөл байдлыг зөвөөр үнэлэн, эрсдпийг хуваарилах  
талаар тохиролцон тогтоож болно.

### **Арав. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, ДУУСГАВАР БОЛОХ, ЦУЦЛАХ**

- 10.1. Энэхүү гэрээг батлагдсан өдрөөс эхлэн 2025 оны 01 дугаар сарын 10-ны  
өдрийг дуустал хугацаагаар байгуулав.
- 10.2. Гэрээ нь талууд гэрээний үүргээ биелүүлсэнээр дуусгавар болно Талууд  
харилцан тохиролсноор Худалдан авалтын захиалга болон гэрээг дуусгавар  
болгож болно.
- 10.3. Нийлүүлэгч барааг нийлүүлээгүй, хугацаа хоцроож нийлүүлсэн,  
доголдолтой, эсхүл үзүүлэлт, шаардлагад нийцэхгүй. ашиглах боломжгүй  
бараа нийлүүлсэн, доголдлыг засах талаар худалдан авагчийн шаардлагыг  
биелүүлээгүй зэргээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл нийлүүлэгч нь  
дампуурсан, татан буугдсан, төлбөрийн чадваргүй болсон нь тогтоогдсон  
бол худалдан авагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдэл хүргүүлсэнээр Худалдан  
авалтын захиалга болон гэрээг нэг талын санаачилгаар цуцлах эрхтэй.
- 10.4. Гэрээ цуцлагдсан бол нийлүүлэгч бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэхийг  
зогсоох ба гэм буруутай тал нөгөө талд учирсан хохирлыг барагдуулна.

### **Арван нэг. БАРИМТЛАХ ХУУЛЬ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

- 11.1. Энэ гэрээг байгуулах, тайлбарлах болон бараа худалдах, худалдан авах  
ажиллагаанд талууд Монгол Улсын хууль тоггоомжийг баримтална.
- 11.2. Талуудын хооронд үүссэн санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг талууд  
харилцан зөвшилцөх журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба ийнхүү  
тохиролцоонд хүрч эс чадвал Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр  
шийдвэрлүүлнэ.



## Арван хоёр. БУСАД ЗҮЙЛ

- 12.1. Худалдан авалтын захиалга болон энэхүү стандарт нөхцөлд талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 12.2. Худалдан авагч болон нийлүүлэгч нь харилцан тохиролцож, бичгээр үйлдэн, гарын үсэг зурж баталгаажуулснаар энэхүү гэрээнд өөрчлөлт оруулж болно.
- 12.3. Гэрээг 3 хувь үйлдэж гэрээний хувиуд зөрчилдсөн тохиолдолд БОАЖЯ-ны Хуулиин хэлтэст хадгалагдаж байгаа хувийг эх хувь гэж үзнэ.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалгийг төлөөлж:

Завхан аймгийн УЦУОШТ  
дарга

Хаяг: ..... З.Мөнгөнцэцэг  
УЦУОШТөв  
Утас: ..... 990649190

И-мэйл хаяг: ..... 09.2070024

Нийлүүлэгчийг төлөөлж:

Нүүдэлчин Эко Ресурс ХХК  
Ерөнхий менежер

Хаяг: Улаанбаатар хот,  
Баянзүрх дүүрэг, 7-р хороо  
2-р байр 112 тоот  
Утас: 94119119  
И-Мэйл хаяг: 6991033 НД1098